

БАТЛАВ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН
ЗАСАГ ДАРГА *А.Эрдэнэсайхан*

БАТЛАВ
“ЭРЭГ ТЭМҮҮЛЭЛ НҮТББ”
ЗАХИРАЛ *Найдан Энхбаатар*

“МАЛЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА” -НЫ АЖЛЫН ГЭРЭЭ
№ ДУГАЦДСЗДТГ/202304016

2023.06.05

Хараат

Нэг талаас Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газар (цаашид “Захиалагч” гэх) түүнийг төлөөлж Засаг дарга А.Эрдэнэсайхан, нөгөө талаас “Эрэг тэмүүлэл ТББ /регистрийн дугаар 8242763/-н тэргүүн Найдан овогтой Эрдэнэбаатар (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нар дараах зүйлсийг харилцан тохиролцож 2023 оны 06 дугаар сарын 05 –ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу ажил гүйцэтгэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын “Малчдад зориулсан сургалт сурталчилгаа”-ны ажлыг ДУГАЦДСЗДТГ/202304016 дугаартай (цаашид “гэрээний үүрэг” гэх) 17,500.000 (Арван долоон сая таван зуун мянга)-н төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь “Малчдад зориулсан сургалт сурталчилгаа” -ны ажлын 17,500.000 (Арван долоон сая таван зуун мянга) -н төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлнэ.
4. Гүйцэтгэгч нь тус сумын “Малчдад зориулсан сургалт сурталчилгаа” ажлыг техникийн тодорхойлолтод заагдсан нөхцлийн дагуу чанартай хийж гүйцэтгэнэ. Ажлыг 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр эхлүүлж 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн дотор гүйцэтгэнэ.
5. Сургалт эхлэхээс өмнө төлбөрийн 70%-ийг шилжүүлж, сургатын дараа 30%-ийг гүйцэтгэгч талын Төрийн банкны 380000029310 тоот дансанд шилжүүлнэ.

6. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

- 6.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 6.2 Бусад шаардлагатай баримт бичиг;
- 6.3 Гүйцэтгэгчийн ирүүлсэн санал;
- 6.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 6.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 6.6 Ажлын зураг, техникийн тодорхойлолт
- 6.7 Гүйцэтгэгчийн ирүүлсэн үнэ бүхий үйл ажиллагааны хуваарь
- 6.8 Санхүүжилтийн хуваарь

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

7. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

7.1. Захиалагч тал дараах эрх эдлэнэ. Үүнд:

- a) Гүйцэтгэгч талын боловсруулсан сургалтын хөтөлбөртэй танилцан, өөрсдийн саналыг тусгуулах эрхтэй.
- b) Гүйцэтгэгч тал болох багшийн заах арга зүй болон ур чадварын, ёс зүй хангалтгүй байсан тохиолдолд багшийг өөрчлөх шаардлага тавих эрхтэй.
- c) Байгууллагын онцлогоос шалтгаалж, сургалтын хуваарьт өөрчлөлт оруулах эрхтэй.
- d) Сургалт дууссаны даруу сургалтын үр дүнг дараах байдлаар дүгнэнэ.
* Суралцагчдаас сургалтын үр дүн болон зохион байгуулалтын талаарх санал асуулга авах
* Шаардлагатай тохиолдолд сургалтын явцад ажилласан дадлага ажил, тараах материалтай танилцах

Дээрх хоёр нөхцөлийг Захиалагч талын зохих албан тушаалтанд танилцуулах байдлаар сургалтын үр дүнг тооцох ба суралцагчдаас авсан сургалтын үнэлгээг хүлээн авна.

7.1.1 Захиалагч тал нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- a) Сургалтад хамрагдах ажилтнуудыг сонгон, сургалтын зарыг тараасан байх үүрэгтэй.
- b) Сургалтын төлбөрийг гэрээнд заагдсан нөхцөлийн дагуу төлөх үүрэгтэй.
- c) Сургалтанд оролцогчдын нэрсийн жагсаалтыг урьдчилан өгнө.
- d) Захиалагч тал сургалт явуулах дараах нөхцлийг хангана. Үүнд:
 - Сургалт явуулах байр, танхимаар хангах
 - Сургалтын завсарлагааны үеэр хэрэглэх цай, кофе, жигнэмэг бэлдэх
 - Сургалтын бэлтгэл ажлыг хангах, захиалагч талын гаргасан удирдамжийн дагуу бэлтгэл ажлыг зохион байгуулахСургалтын сургагч багш нарын хоолны зардлыг хариуцна.

7.2. Гүйцэтгэгч талын эдлэх эрх, хүлээх үүрэг

7.2.1 Гүйцэтгэгч тал нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- a) Сургалтын төлбөрийг хугацаандаа төлөхийг шаардах эрхтэй.
- b) Сургалтанд хамрагдаж буй суралцагч нарт хичээлийн дундаас гарч явахгүй байх гэх мэт ёс зүйн шаардлага тавих эрхтэй.
- c) Сургалтанд оролцогч нараас сургалттай холбоотой тест, шалтгалт авах эрхтэй.
- d) Сургалтыг чанартай явуулах зорилгоор ажилтнуудтай уулзаж, тэдэнд тулгарч байгаа бэрхшээл, ажлыг сайжруулах талаар ярилцах эрхтэй.

Гүйцэтгэгч талын хүлээх үүрэг:

- a) Сургалтын хөтөлбөрийг 2 үе шаттай бэлтгэн Захиалагч талд танилцуулж батлуулна.
- b) Сургалтын хөтөлбөрийн дагуу явуулах, Хичээлийг хөтөлбөрийн дагуу сонирхолтой, чанартай, үр өгөөжтэй байдлаар явуулахад бүрэн анхаарч ажиллах үүрэгтэй.
- c) Сургалтын гарын авлагыг сургалтын оролцогчдод бэлдэх ажлыг хариуцна.
- d) Сургалтын явцад Захиалагч талаас гаргасан санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн, багшийн ёс зүйг сахиж суралцагч нарт хүрч сургалт явуулах үүрэгтэй.
- e) Гэрээтэй холбоотой Захиалагч талаар олж мэдсэн бүхий л мэдээллийг аливаа хэлбэрээр гуравдагч талд задруулахгүй байх үүрэгтэй.
- f) Суралцагчид сургалтын хөтөлбөрийн агуулгатай холбоотой, бэлдэж боловсруулсан тараах материалаар бүрэн хангах үүрэгтэй.
- g) Сургалтын төгсгөлд суралцагчдаас үнэлгээ авч, сургалтын тайланг Захиалагч талд танилцуулах үүрэгтэй.
- h) Гэрээний хавсралтын дагуу суралцагчдын ирцийг бүртгэж сургалт бүрэн дуусмагч Захиалагч талын хариуцсан ажилтанд өгнө.
- i) Сургалт бүрэн дууссаны дараа бэлтгэгдсэн сургагч багш нарт зөвлөгөө өгөх үйлчилгээг 1 удаа үзүүлэх

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

9. Ажлыг гэрээт хугацаандаа гүйцэтгээгүй бол хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 3 хувиар алданги ногдуулна. Гэхдээ алданги хүлээснээр үүргийн гүйцэтгэлээс чөлөөлөгдөхгүй.


12. Захиалагч болон гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас үл хамааран ажил гүйцэтгэх хугацаанд саатал гарсан тохиолдолд хамтран тохиролцож, ажлын графикт зохицуулалт хийсний үндсэн дээр ажил дуусгах хугацаанд өөрчлөлт оруулж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЦАГААНДЭЛГЭР СУМЫН

ЗДТГ-ЫН ДАРГА

 Ш.МӨНХ-ОРГИЛ

ХАЯГ: Дундговь аймгийн Цагаандэлгэр
сум Хараат 1-р баг

Утас: 95971666

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ЭЭРЭГ ТЭМҮҮЛЭЛ” ТББ-ЫН
8242763 1117241439
ТӨЛӨӨЛӨЛ



ХАЯГ: Улаанбаатар, Баянзүрх, 6-р хороо
13-р хороолол, к 2,30 тоот

Харилцах банк: Төрийн банк

Регистрийн дугаар: 8242763

Утас: 90099099